


БАТЛАВ:  
 НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН  
 АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
 ДАРГА  М.БАЯРАА

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,  
 НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Төсөв, эх үүсвэр (мян.төг)	Хариуцах нэгж, ажилтны нэр	Хугацаа /сар, улирал/
	1	2	3	4	5
1	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ур чадварын нэмэгдлийг шийдвэрлүүлэх	Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн хэрэгжилт хангагдаж, төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдэнэ.		Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал	I улиралд

2	Байгууллагын албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцанд хамруулах үйл ажиллагааг эхлүүлэх	Амьдрах нөхцөл сайжирч, нийгмийн асуудал шийдэгдэнэ.		Захиргаа, санхүүгийн хэлтэс /Удирдлагууд/	Жилдээ
3	Албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэн, улирал тутам урамшуулал олгох	Төрийн албан хаагчдын нэмэгдэл баталгаа хангагдана.	Төсөвт тусгагдсан.	Захиргаа, санхүүгийн хэлтэс	Улирал тутам
4	Хүүхдийн баяр, Шинэ жилийн баяраар албан хаагчдын 0-16 насны хүүхдүүдэд бэлэг гардуулах ажлыг зохион байгуулах	Ажилтан, албан хаагчдын амьжиргаанд дэмжлэг үзүүлнэ.	Төсөвт тусгагдсан. /3 850,0/	Захиргаа, санхүүгийн хэлтэс	Жилд 2 удаа
5	Байгууллагад ашиглагдаж байгаа компьютер, техник хэрэгслийн элэгдлийг тооцсоны үндсэн дээр шаардлагатай техник хэрэгслийг шинэчлэх арга хэмжээ авах	Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог бүрэн хангаж, үйл ажиллагаа сайжирна.		Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Уранчимэг, Д.Батбаяр	II, III улиралд
6	Үйлчилгээний ажилтнуудыг хөдөлмөрийн багаж хэрэгсэл, өвөл, зуны ажлын хувцсаар хангах	Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог бүрэн хангаж, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.	3,0 сая	Захиргаа, санхүүгийн хэлтэс А.Мөнгөн Н.Уранчимэг	III улиралд

7	Үйлчилгээний ажилчдад Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын сургалт зохион байгуулах	Ажлын байрны аюулгүй ажиллагаа хангагдана.		Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал	II улиралд
8	Албан хаагчийн ар гэрт гачигдал тохиолдох, хүндээр өвдөж, урт хугацааны турш ажил хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд тусламж, дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа сайжирна.	2,0 сая	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал	Жилдээ
9	Галлагаатай гэр байшинд амьдардаг ажилтан, албан хаагчдын өвөлжилтийн бэлтгэлд зориулан сайжруулсан шахмал түлш худалдан авахад дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх	Ажилтан, албан хаагчдын амьжиргаанд дэмжлэг үзүүлнэ.	3,5 сая	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал, Н.Уранчимэг	IV улиралд
10	Хөдөлмөрийн болон нийгмийн идэвхийг өрнүүлэхэд чиглэсэн чөлөөт цаг, амралтыг зөв зохистой өнгөрүүлэх талаар тодорхой ажлууд зохион байгуулах	Ажилтан, албан хаагчдын хамт олонч, эерэг уур амьсгал бүрдэн, багаар ажиллах чадвар сайжирна.		ЗСХ, ӨТМХ, ӨБХХ, ӨМХАХ	Жилийн турш
11	Ажлын байрны эрүүл ахуй, эрүүл мэндийн анхан шатны тусламжийн багаж хэрэгсэл, эм бэлдмэлээр тогтмол хангах	Ажиллах таатай нөхцөл бололцоо хангагдана.	500,0	Захиргаа санхүүгийн хэлтэс, ХАБ ажилтан	Жилийн турш

12	Ажил үүргээ идэвх зүтгэл, үр дүнтэй биелүүлж, өндөр амжилт гаргасан албан хаагчдыг шагнал урамшуулалд тодорхойлох	Ажилтан, албан хаагчдын ажиллах урам зориг, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.		Захиргаа санхүүгийн хэлтэс Н.Золжаргал	III, IV улиралд
Нийт					

Танилцсан:

Орлогч дарга

Орлогч дарга

Хянасан:

ЗСХ-ийн дарга

Боловсруулсан:

ЗСХ-ийн ахлах мэргэжилтэн

Д.Төмөрбаатар

Д.Рэнцэнбямба

А.Мөнгөн

Н.Золжаргал